

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ БИЕЛЭЛТ

2026 оны 01 дугаар сарын 05

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Биелэлт
1. ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ				
Хуульчдын Их Хурал				
1.1	Их хурал зохион байгуулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Их хурлыг зохион байгуулсан байна.	МХХ-ны Зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хуульчдын 6 дугаар Их хурал зохион байгуулах Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Тамгын газрын даргын даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/31 тушаалаар “Хуульчдын 6 дугаар Их хурал зохион байгуулах Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг” байгуулан, мөн тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу ТГ-ын нийт ажилтнууд оролцож, өөрийн хариуцсан ажлыг гүйцэтгэн ажилласан. Тухайлбал, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн, Дэд ажлын хэсгийн НБД-аар мэргэжилтэн Э.Алтанзул, Хуульчдын холбооны дүрэмд өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийн НБД-аар мэргэжилтэн Г.Болор-Эрдэнэ, Хяналтын хэсгийн НБД-аар мэргэжилтэн Э.Нарангэрэл нар ажилласан. Хуульчдын 6 дугаар Их хурлыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Корпорэйт конвеншн центрт зохион байгуулсан ба хурлын үйл ажиллагаатай холбоотой цаасан болон цахим архивыг бэлтгэж байна.
Зөвлөл				
1.2	Зөвлөлийн үйл ажиллагаа явуулах журмын хүрээнд тухай бүр зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах	Жилдээ	Зөвлөлийн хурлыг зохион байгуулсан байх.	Тайлант хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Хуульчдын холбооны зөвлөл нь Хуульчийн эрх зүйн

				байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, цаг үеийн асуудлаар нийт 10 удаа хурал зарласан. Үүнээс 1 удаа ирц хүрээгүй шалтгаанаар хурал хүчин төгөлдөр бусад тооцогдож, 9 удаа ээлжит болон ээлжит бусаар хуралдсан байна. Эдгээр хурлаар нийт 36 асуудал хэлэлцэж, хэлэлцсэн асуудлын хүрээнд нийт 27 тогтоол гаргасан байна. 2022-2025 онд үйл ажиллагаа явуулсан зөвлөл 49 гишүүнтэй байсан бол Их хурлын 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 55 гишүүнийг батламжилсан. Шинэ Зөвлөл байгуулагдсантай холбогдуулан Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд анхны хурлыг 12 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан болно. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Холбооны дүрэмд заасны дагуу МХХ-ны Зөвлөлийн 2023-2025 оны 3 жилийн тайланг бэлтгэж Хуульчдын Их хурлын төлөөлөгчдөд танилцуулсан.
Хяналтын зөвлөл				
1.3	1.4.Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг явуулах	Жилдээ	Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, холбогдох, дүрэм журмын дагуу явуулахад дэмжлэг үзүүлэх	2025 онд Хяналтын зөвлөл хууль тогтоомжид заасан хугацаанд 3 удаа ээлжит болон ээлжит бусаар хуралдсан. 05 дугаар сарын 30, 10 дугаар сарын 15-ны өдөр тус тус хуралдаж Хяналтын зөвлөлийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг хангах, хууль, дүрэмд заасан МХХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хуваарийг баталсан бол 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийг Тамгын газарт хүргүүлэх, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах асуудлыг хэлэлцэж холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гаргасан

				байна. Хяналтын зөвлөлөөс 2022-2025 онд МХХ-ны санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны 3 жилийн тайланг боловсруулж Хуульчдын 6-р Их хуралд танилцуулсан. Мөн Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа болон ТГ-ын 2024 оны бүтэн жил, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шалгалтын дүнг 11 дүгээр сарын 28-ны өдрийн Зөвлөлийн хуралд танилцуулсан.
Тамгын газрын үйл ажиллагаа				
Чиг үргийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулах				
1.4	Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах багц цаг хангах журмын хэрэгжилтэд хяналт тавих, сургалтын чанар, үнэлгээнд өгсөн дүнг нэгтгэх, танилцуулах	Улирал тутам	Сургалтын чанар сайжирч гомдол, барагдсан байна.	Сургалтын хэрэгцээ үр дүнгийн талаарх судалгааг авсан Хорооны гишүүн, холбооны судлаач Г.Оюунболд судалгааны дүнг нэгтгэн танилцуулсан.
1.5	Сургалтын төлбөрийг хугацаанд нь барагдуулж буй эсэхэд хяналт тавих;	Улирал тутам	Төлбөрийн тооцоогүй болсон байна.	Сургалтын төлбөрийг тухай бүр барагдуулан ажиллаж байна. Сургалтын төлбөрийг хуульчид Qрау төлбөрийн системээр төлж сургалтаа идэвхжүүлж байна. Сургалтын бүртгэлийг төлбөр төлөлттэй тулган шүүлт хийж Тамгын дарга болон холбогдох мэргэжилтнүүд хянан багц цагийг тооцож байна.
1.6	Холбооны нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй гишүүдийн татварын болон сургалтын төлбөр тооцооны мэдээ тайлан гаргах, холбооны цахим хуудаст байршуулах, тэднийг байнгын мэдээллээр хангах ажлыг хариуцан зохион байгуулах, орлогыг бүрдүүлэх;	Улирал тутам	Гишүүний төлбөр тооцоо өр авлага тухай бүр чирэгдэлгүй барагдана.	Татварын тооцоог тухай бүр хуульчийн цахим хуудаст бүртгэж байна. Qрау төлөлт системд автоматаар бүртгэгдэж хянагддаг. Татвар болон сургалтын төлбөрийн талаарх мэдээллийг 70116364 (2) утсаар хүргэн ажиллаж байна. 2025 оны 01 сард 343 хуульчид татварын мэдэгдэл хүргүүлж төлөлтийг бүртгэв. 2025 оны 01 сарын 30-ны өдрийн 28 дугаар тушаалаар гишүүний татвараа төлөөгүй 193 хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гишүүнчлэлийн эрхийг хүчингүй

				болгож шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд нийт хуульчдад 6 удаа татвар төлөх тухай мессеж илгээж төлөлтийг бүртгэсэн. Татварын үлдэгдэл 500,000 төгрөг ба түүнээс дээш үнийн дүнтэй хуульчдад 4 удаа мессеж илгээж төлөлтийг бүртгэсэн. 2025 оны 05 сарын 27-ны өдөр татварын үлдэгдэл 500,000 төгрөг ба түүнээс дээш 719 хуульчийн дугаараар холбогдож мэдээлэл хүргэж ажилласан.
1.7	Холбооны нэгдсэн (цаасан болон цахим) бүртгэлийг хөтлөх	Жилдээ	Шинэчлэгдсэн лавлагааг нийтэд мэдээлсэн байна.	Хуульчдын нэгдсэн бүртгэлийг бүртгэлийн нэгдсэн системд тухай бүрт бүртгэж баталгажуулж, бүртгэлтэй холбоотой өөрчлөлт мэдээллийг тухай бүрт бүртгэж цахимжуулж, мөн цаасан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж байна. Нийт бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хуульчдын мэдээлэл: 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 6610 хуульч бүртгэгдсэн байна. Үүнээс: шүүгч 520, Прокурор 620, Өмгөөлөгч 2064, Нотариат 262, Бусад хуульч 3144 тус тус бүртгэлтэй байна.
1.8	Хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн цаасан бүртгэлийг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх	Тухай бүр	Бүртгэл тодорхой болсон байна.	Холбооны эрх бүхий этгээдээс хууль, Холбооны дүрэм болон бусад дүрэм, журамд заасны дагуу Холбооны гишүүдээр дагаж мөрдүүлэхээр гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих нийтэд болон гишүүдэд мэдээллэх зорилгор Холбооны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг Холбооны бүртгэлд бүртгэдэг. Бүртгэлийн нэгдсэн журамд хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн цаасан бүртгэлийг хөтлөх тухай заасныг баримтлан 2 дүрэм (Монголын Хуульчдын холбооны дүрэмд 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан), 29 журмыг бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлэн хадгалж байна.

1.9	Хуульчийн үүргийн биелэлтэд хяналт тавих	Жилдээ	Судалгааг зохих журмын дагуу хийсэн байна.	2025 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар 1 сая ба түүнээс дээш төгрөгийн татварын үлдэгдэлтэй нийт 343 хуульчдад 01 дүгээр сарын 13-наас 24-ний өдрийн хооронд гишүүнчлэлийн татвар төлөх, төлөөгүй тохиолдолд хүчингүй болгох тухай мэдэгдлийг хүргэж, 2025.01.30-ний өдрийн №28 дугаар ерөнхийлөгчийн тушаалаар 192 хуульчийн эрхийг хүчингүй болгосон. Мөн 2025 оны 05 сарын 27-ны өдрийн байдлаар 500,000 төгрөг ба түүнээс дээш төгрөгний үлдэгдэлтэй байгаа 719 хуульчид татварын үлдэгдлийг мэдэгдэх ажиллагааг 05 сарын 27, 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан.
1.10	Шинэ хуульчид гэрчилгээ олгох, тангараг өргүүлэх, нэгдсэн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн байх	1. Монголын Хуульчдын холбооны Бүртгэлийн нэгдсэн журмын 2.3 дугаар зүйлийн 1.2, 4.2 дугаар зүйлийн 2, 4.4 дүгээр зүйлийн 1, 4.5 дугаар зүйлийн 1, 3, 11.7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн тайлангийн хугацаанд 82 иргэнийг гишүүнээр элсүүлж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. Үүнд: а/.МХХ-ны Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №249 дугаартай тушаалаар 2025 оны хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж батламж авсан 81 иргэнийг, б/.МХХ-ны Ерөнхийлөгчийн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №258 дугаартай тушаалаар, ХЭЗБТХуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасан үндэслэлээр ХМҮАЭЗ олгох ажиллагааг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тул Г.Дэлгэржаргалыг тус тус хуульчдын холбооны гишүүнээр элсүүлж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. 2. Тангараг өргүүлэх ажлын хүрээнд: Холбооны

				Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №249 дугаартай тушаалаар бүртгэгдсэн, 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж батламж авсан 81 хуульчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 14:00, 15:00 цагуудад зохион байгуулсан. 81 шинэ хуульчийн тангарагыг өргүүлж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг Монгол, Англи хэл дээр олгох үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.
1.11	Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах дэд ажлын хэсгийг байгуулж, зохион байгуулах	Жилдээ	Хуульчийн мэргэжлийн шалгалтын хороонд дэмжлэг үзүүлэн ажиллах	2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах дэд ажлыг хэсгийн ахлагчаар Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Нарийн бичгийн даргаар Б.Аззаяа, гишүүдээр Тамгын газрын мэргэжилтнүүд ажиллаж, нийт 26 ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, Зохион байгуулалтын комисст дэмжлэг үзүүлж ажиллав. Тодруулбал, 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтыг 10 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод 6 байршилд зохион байгуулсан. Нийт 1127 оролцогч шалгалт өгснөөс 100 оролцогч сорилгын болон бодлогын шалгалтын нийлбэр дүнгээр 70 ба түүнээс дээш оноо авч, хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн.
1.12	Хуульчийн үргэлжилсэн сургалт, албан бус сургалтуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Сургалтыг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулсан байх.	2025 онд нийт 33 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2051 хуульч хамрагдснаас 21 сургалтыг танхимаар, 6 сургалтыг цахимаар бусад байгууллагатай хамтарсан 6 сургалт зохион байгуулсан.
1.13	Багц цаг тооцох хүсэлт хүлээн авах, хорооны хурлаар шийдвэрлүүлэх, хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан хуульчдын кредитийг цахим санд шивж, баяжилтыг тухай бүр хийх	Тухай бүр	Хуульчийн үүргийн биелэлтийг хангуулах	Багц цаг тооцуулах 282 хүсэлт хүлээн авч, Сургалтын хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн.

Хуульчдын холбооны орон нутаг дахь салбар нэгжийн үйл ажиллагаа				
1.14	Хуульчдын холбооны орон нутаг дахь салбарыг арга зүйн удирдлагаар хангах	Тухай бүр	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах	Өвөрхангай аймгийн салбарын зохицуулагчийн гэрээний хугацаа дууссан, Дундговь аймгийн салбарын зохицуулагч шүүгчээр томилогдож хүсэлтээ ирүүлсэн тул тус аймгийн салбарын зохицуулагчдыг шинээр томилж, ажлыг хүлээлцүүлсэн.
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах				
1.15	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах.	01-03 сард	Хуульчдын холбооны үйл ажиллагааны мэдээ мэдээлэл олон нийт болон хуульчдад нээлттэй, түргэн шуурхай хүрдэг болно.	Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл болон Бизнесс.мн цахим хуудастай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн гэрээгүй ч МҮОНРТ, Монгол ТВ, Тэнгэр ТВ, Өнөөдөр сонин, цахир.мн-д шаардлагатай мэдээллүүдээ үнэ төлбөргүй нийтлүүлэн хамтран ажиллаж байна.
1.16	Хуульчдыг олон нийтэд таниулах хүрээнд хөрөг нэвтрүүлэг, нийтлэлийн буланд оролцуулах, Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх.	Жилдээ	Хуульчдыг олон нийтэд сурталчлах, хуульчийн үүргийг олон нийтэд таниулж, олон нийт зөв мэдээлэлтэй болно.	Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл болон Бизнесс.мн цахим хуудастай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн гэрээгүй ч МҮОНРТ, Монгол ТВ, Тэнгэр ТВ, Өнөөдөр сонин, цахир.мн-д шаардлагатай мэдээллүүдээ үнэ төлбөргүй нийтлүүлэн хамтран ажиллаж байна.
1.17	Хууль эрх зүй, нийгмийн асуудлаар сошиал пост бэлтгэж нийтлэх.	Жилдээ	Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд түлхэц болно.	Хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллаж, холбооны мэдээ, мэдээллийг нийтлүүлэх, хуульчдыг нийгэмд таниулах мэдээлэл, ярилцлага өгүүлэх, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх нэвтрүүлгүүдэд хуульчдыг оролцуулах зэрэг ажлын хүрээнд нийт 25 ажлыг гүйцэтгэв. Түүнчлэн эрх зүйн мэдлэг олгох, хууль эрх зүйн асуудлаар тодруулага яриа өгөхөд сэтгүүлч, хуульчдыг тухай бүр холбон ажиллав.
1.18	Холбооноос зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг боловсруулж, олон нийтэд сурталчлах	Жилдээ	Холбооны үйл ажиллагааг олон нийтэд хүргэх	“Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” олон улсын хурлын илгэгчдийн онцлох эшлэлүүдээр постер бэлтгэн цувралаар нийтлэв. - Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороо, Иргэний эрх зүйн хорооноос бэлтгэсэн подкастуудыг нийтэлж олон нийтэд түгээв. - Хуульчдыг эвлэрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлж байхыг урилсан постер бэлтгэж нийтлэв

				- Азийн про боно 13 дахь чуулга уулзалтын түрээнд Майнд эженси байгууллагатай хамтран нийт 15 постер бэлтгэн нийтлэв. - Хуульчдын их хуралтай холбоотой мэдээлэл өгөх 8 постер бэлтгэн нийтлэв.
1.19	Мэргэшсэн чиглэлээр хэвлэл мэдээлэлд тайлбар өгөх, зөвлөгөө мэдээлэл өгөх хуульчдын нэрсийг жагсаалт гаргах	Жилдээ	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг түгээх	Тайлангийн хугацаанд Хуульчдын холбооноос зохион байгуулсан болон хуульчдад хүргэхийг зорьсон мэдээ, мэдээллийг бэлтгэн Холбооны албан ёсны цахим хуудас болон фэйсбүүк хуудаст нийтэлж хуульчдад хүргэв. Тодруулбал, холбооны цахим хуудаст нийт 326 мэдээ, мэдээлэл, фэйсбүүк хуудаст 365 пост, мэдээ, мэдээлэл нийтэлсэн байна.
Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа				
1.20	Хуульчийн про-боно өдөрлөгийг зохион байгуулах	5 дугаар сарын 01	Өдөрлөгийг зохион байгуулсан байх	Жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг Хуульчийн Про боно өдрийг 7 дахь жилдээ Сүхбаатарын талбай болон 21 аймгийн төв талбай, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ төв, алслагдсан хороод, тойргийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийн гадна талбайд зохион байгуулсан. Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газар, Хан-Уул дүүргийн Прокурорын газар, Чингэлтэй дүүргийн Прокурорын газар, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар, Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газар, Баянгол дүүргийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Хүний Эрхийн Үндэсний комисс, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн

				ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Өмгөөллийн "Легал гайд" ХХН, "Сноухилл консалтанси" ХХН, Өмгөөллийн "Цогц өмгөөлөл" хууль зүйн фирм, Өмгөөллийн Легал полиси ХХН, "Легас атторнийз" хуулийн фирм, "Легал сервис" ХХН, "Эм Жи Эл атторнийз" хуулийн фирм, "Чирха өвгөн" ХХН, "Компасс консалтинг" хууль зүйн фирм, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төв, "Анбаунд Монгол" ТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци зэрэг 20 гаруй байгууллага оролцож иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч, төрийн зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн. Хуульчийн Про боно өдрийн хүрээнд Нийслэл болон орон нутгийн хэмжээнд нийт 13,378 иргэнд хууль зүйн, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Мөн тус өдрийг угтаж Нийслэл болон 21 аймгийн Ерөнхий боловсролын 8-11 дүгээр ангийн сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр нийт 72 сургуулийн 7906 сурагчид сургалт зохион байгуулсан. Сургалтаар гэмт хэргийн тухай ойлголт, цахим гэмт хэрэг, түүний хохирогч болохоос урьдчилан сэргийлэх болон цахим донтолтын талаар сурагчдад таниулан, мэдээлэл өгсөн. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлын хүрээнд тус сургалтад орон нутгийн шүүхийн шүүгчид, Нийслэл, дүүрэг, орон нутгийн Прокурорын газрын прокурорууд, хуульч, өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, 21 аймгийн салбарын зохицуулагчид нийлсэн нийт 76 хүн сургагч багшаар
--	--	--	--	--

				ажилласан.
Сайн дурын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх				
1.21	Сайн дурын хороодоос зохион байгуулж байгаа уулзалт, хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд хүний нөөцийн болон, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байх	Хороодоос зохион байгуулсан 34 хэлэлцүүлгийг Тамгын газраас хамтран зохион байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн.
Бодлогын нөлөөлөл үзүүлэх				
1.22	Хуульчдын форум, хэлэлцүүлэг, оны шилдэг хуульч шалгаруулах Фемида арга хэмжээ, хэлэлцүүлгийг зохион байгуулах	Жилдээ	Холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	1.Монголын Хуульчдын холбооны Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хорооноос Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дэмжлэгтэйгээр “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн форум-2025” үйл ажиллагааг 2025 оны хоёрдугаар сарын 21-ний өдөр анх удаа зохион байгуулж, дараах илтгэлийг хэлэлцүүлж, форумаас өмгөөллийн хуулийн этгээдүүдийн татварын орчинг сайжруулах, харилцан сайн туршлага солилцох, шинэ техник технологийг нэвтрүүлэх талаар санал, зөвлөмж, холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр болсон. Үүнд. - “Өмгөөллийн хуулийн этгээдийн татварын орчин”, - “Өмгөөллийн үйл ажиллагааны зах зээлийн орчин”, - “Хиймэл оюун ухаан (AI) хуулийн салбарт нөлөөлөх нь, цаашдын чиг хандлага”, - “Шүүхийн цахимжилт”, “Хялбар ажиллагааны шүүхийн цахимжилт” сэдвээр мэдээлэл өгсөн. 2. Оны шилдэг хуульчдыг шалгаруулах “Фемида-2025” ёслолын ажиллагаа 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Тус ёслолын зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар Тамгын газрын дарга Ш.Жолбарс, нарийн бичгийн даргаар мэргэжилтэн Б.Аззаяа, гишүүдээр Зөвлөлийн гишүүн С.Ганбат, С.Санчир, Б.Батцэнгэл,

				М.Энхжин, З.Оюун-Эрдэнэ, Б.Баярмагнай, Г.Бямбасүрэн нар ажиллаж, нийт 37 ажлыг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу ёслолын ажиллагааг зохион байгуулж ажилласан. Тус ёслолын ажиллагааг нь шилдэг хуульчдыг алдаршлуулах зорилготой бөгөөд дараах хуульчид 2025 оны шилдэг хуульчаар тодорлоо. Үүнд: • Шилдэг хуульч эрдэмтнээр Батболдын Амарсанаа, • Шилдэг хуульч-шүүгчээр Төмөрбаатарын Өсөхбаяр, • Шилдэг хуульч-Прокуророор Бадамжавын Батсайхан, • Шилдэг хуульч-өмгөөлөгчөөр Базаррагчаагийн Бат-Ерөөлт, • Шилдэг хуульч-Нотариатчаар Пүрэвдоржийн Цэцэгмаа, • Шилдэг хуульч-Хуулийн Зөвлөхөөр Хутгаагийн Тэмүүжин, • Шилдэг хуульч-Мэргэжилтнээр Төмөрийн Баясгалан, • Шилдэг Про-боно хуульчаар Цэнджавын Одонжав, • Шилдэг салбарын зохицуулагчаар Намсрайн Бүрэнчимэг, • Шилдэг хуульч-Улсын Өмгөөлөгчөөр Чадраабалын Будхүү, • Шилдэг залуу хуульчаар Батбаярын Батцэнгэл, • Шилдэг өмгөөллийн нөхөрлөлөөр "Өмгөөллийн Легал Гайд" ХХК, • Шилдэг хороогоор Д.Түмэнжаргал тэргүүнтэй Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороо, • Шилдэг ахмад хуульчаар Цэвэлмаагийн
--	--	--	--	---

				Мөнхбат • Шилдэг Олон Улсын хуульчаар Мөнхбаярын Номинцэцэг нар тус тус шалгарлаа. “Фемида-2025” ёслолын ажиллагааг зохион байгуулахад “Грата Интернэшнл Монголиа” олон улсын хуулийн фирм, Өмгөөллийн “Анта партнерс” ХХК, “Сүлд Эм Жи Легал” ХХН, “Компас консалтинг” ХХК, “Лекс консалтинг Бюро” ХХК, “Чимид” сан, “Номин” ХКК-ийн Эрх зүйн газар зэрэг байгууллага дэмжлэг үзүүлж ажиллав.
1.23	Хуульчдын төгөлд мод тарих, нийгэмд чиглэсэн сайн дурын ажил зохион байгуулах, хуульчдын дунд спорт тэмцээн, эрүүл мэндийн өдөрлөг, явган аяллын тэмцээн зэргийг зохион байгуулах	Жилдээ	Хуульчдыг идэвхжүүлэх	Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны нийт гишүүдийн уулзалт, Иргэний эрх зүйн хорооноос зохион байгуулсан хуульчдын цасны баяр арга хэмжээг хамтран зохион байгуулав.
1.24.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Хуулийн этгээд энэ хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах	Жилдээ	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.	- МУТСТҮХ-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монголын Хуульчдын холбоо 2025 оны төлөвлөгөөг батлаж, хэрэгжилтийг хангаж ажилласан. - Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан Комплаенсын ажилтныг мэргэшүүлэх сургалтуудад хуульчдыг болон ТГ-ын комплаенс хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан. - МХХ-ны МУТС-ээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн төсөл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх журмын төсөл, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны эрсдэлийг үнэлэх зайны хяналт хяналт шалгалтын асуулгын төсөл, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

				тогтолцооны эрсдэлийг үнэлэх газар дээрх хяналт шалгалт хийх зөвлөмжийн төслийг тус тус боловсруулж Зөвлөлийн 2025.05.02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй. - Монголбанкны СМА-гаас МХХ-ны Зөвлөлийн гишүүдэд зориулан МУТСТ тогтолцооны талаар сургалт зохион байгуулсан. - Санхүүгийн мэдээллийн албанд улирал бүр статистик, тоо мэдээг маягын дагуу, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг боловсруулж хүргүүлсэн. - ФАТФ-ын хориг арга хэмжээний жагсаалтад орсон улс орнуудын мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан. - ФАТФ-ын санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн үнэлгээний үндсэн болон Модул 7 дэд ажлын хэсгийн 3-р багийн гишүүнээр ажиллаж ажлын хэсгийн 11 удаагийн хуралд оролцож, үндэсний үнэлгээний тайланг эцэслэн боловсруулж байна. - Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хуудсыг бөглөхөд шаардлагатай мэдээлэл цуглуулах зорилгоор “Хуульч, өмгөөлөгчдөөс авах асуумж”-ийг боловсруулж МХХ-ны нэгдсэн бүртгэлд “бусад хуульч” төрөлд бүртгэлтэй 1700 орчим хуульчаас асуумжийн судалгаа авахаар масс имэйл илгээснээс 46 хариулт ирсэн бөгөөд эдгээр хариултуудад боловсруулалт хийж үнэлгээнд ашигласан. - Мөн МУТСТХ-д заасан МХХ-ны хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал үүсгэж буй эрх зүйн орчны зөрчил, хийдлийн судалгаа хийж үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланд оруулсан. - 2025.10.08-ны өдөр ХАЗ-ын дэргэдэх
--	--	--	--	---

				Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсгийн хуралд оролцсон. - 2025.11.04-ний өдөр СМА-тай хамтран ҮЭҮ-ний тайлангийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. - 2025.12.10-ны өдөр СЗХ-ны зохион байгуулсан үндэсний эрсдэлийн үнэлгээчдийг мэргэшүүлэх сургалтад Компаенс хариуцсан мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн хамрагдсан.
Олон талт хамтын ажиллагаа				
1.25	Хуульчдын холбооны гадаад харилцааг хөгжүүлэх	Жилдээ	Холбооны гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэд олон нийтэд сурталчилсан байх	- 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр (1,270 Английн фунт) төлсөн. ОУБХ-ноос 03 дугаар сарын 15-ны өдөр 2025 оны гишүүнчлэл баталгаажсан мэйл ирсэн. - Ази Номхон далайн Хуульчдын холбоо /LAWASIA/-ны 2025 оны гишүүнчлэлийн хураамж 550 австрали доллар төлсөн. - ОУЭХБ нь Канад Улсын Засгийн газрын Санхүүжилтээр “МУ-д жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийг 2019-2023 оны хооронд хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төслийн хоёрдугаар шатны хэрэгжилт 5 жилийн хугацаатай эхэлж тус төсөлд Монголын Хуульчдын холбоо хамтран ажиллахаар болсон. - АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөтөлбөрийн Олон улсын зөвлөх хуульч Гришма Прадханыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож, төр хувийн хэвшлийн түншлэл болон хиймэл оюун ухаан, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хамтран ажиллахаар тохиролцсон.
1.26	Хуульчдын холбооны хамтын ажиллагааг өргөжүүлэх	Жилдээ		1.Азийн 13 дахь удаагийн Пробоно чуулга уулзалтыг зохион байгуулав.

			2.Олон Улсын барын холбооны ээлжит чуулга уулзалт 11 дүгээр сарын 2-ноос 8-ны хооронд Торонто хотод зохион байгуулагдсан бөгөөд Зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Тамгын дарга Ш.Жолбарс нар оролцсон. 3.Хуульчдын холбооны гишүүн, хуульч Ж.Хунан 10 дугаар сарын 11-13 ны өдрүүдэд Вьетнам улсын Ханой хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн 38 дахь удаагийн ээлжит чуулга уулзалтад МХХ-г төлөөлж 2026 онд зохион байгуулагдах Ази, Номхон далайн бүсийн хуульчдын холбооны олон улсын хүний эрхийн 6-р бага хурал болон 2027 онд болох 39 дэх удаагийн ээлжит чуулга уулзалтуудыг тус тус Монгол Улсад зохион байгуулах эрхийг авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцсон.
1.27	Гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, өргөжүүлэх	Жилдээ	1.Монголын Хуульчдын холбоо, Герман Европын эрх зүйн төв, УИХ-ын Парламентийн сургалт, судалгаа, хөгжлийн хүрээлэнтэй хамтран “Цахим эрх зүйн олон улсын чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэгийг 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан. 2.2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Монголын Хуульчдын холбоо нь АНУ-ын Аризона мужийн Барын холбоотой өдөр цахим уулзалт хийлээ. 3.“Орчин үеийн хуулийн салбар дахь нарийн төвөгтэй байдлыг даван туулах стратегиуд” сэдэвт хуульчийн карьер, хөгжлийн тусгай сургалт, хэлэлцүүлгийг 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. 4.Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнтэй хамтран “Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025.05.14-ны өдөр зохион

				байгуулсан. 5.БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Хан Ён Сү тэргүүтэй төлөөлөгчид 05 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Монголд зочилсон бөгөөд Төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Монголын Хуульчдын холбоо нь БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд харилцан илтгэл тавих, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг ажлуудыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд 2025 онд хууль эрх зүйн олон талт судалгааны ажлуудад харилцан дэмжлэг үзүүлэх болон зочин судлаачийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролсон. 6.Канадын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх комиссарын газраас “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд (EJAM)” нь төслийг хэрэгжүүлж буйтай холбоотой тус төслийн багийн гишүүн Нью Брансвик мужийн Ерөнхий шүүгч Марк Ричард, Канадын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх комиссарын газрын Олон улсын хөтөлбөрийн хэлтсийн дарга Олег Шахов, хуульч, олон улсын хөгжлийн мэргэжилтэн Ян Моррисон нартай 05 дугаар сарын 21-ний өдөр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс уулзалт хийсэн. 7.Германы Касселын их сургуулийн Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн эрх зүйн тэнхимийн профессор, Германы холбооны нийгмийн хамгааллын шүүхийн хүндэт шүүгч Феликс Вельти, Касселын их сургуулийн докторант, судлаач С.Амармэнд нарыг 05 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч уулзсан. 8.Ханнс Зайдел сангийн Мюнхен дэхь төвийн төслийн зохицуулагч Анна Саатбергер болон Монгол дахь
--	--	--	--	---

				суурин төлөөлөгч Феликс Гленк нарыг 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр хүлээн авч уулзсан. 9.ӨМӨЗО-ны Ордос хотын Хуульчдын холбооны төлөөлөгч нарыг 06 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч уулзсан. 10.АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн захирал Эмма Ломаск, АНУ-ын Холбооны Шүүхийн Дипломат албаны Гадаад харилцааны хэлтсийн захирал Мира Гур-Ари, АНУ-ын Холбооны шүүхийн шүүгч Сюзанна Митчелл нарыг 2025.06.20-ны өдөр хүлээн авч уулзлаа 11.АНУ-ын “Зочин илтгэгч” хөтөлбөрийн хүрээнд Монголын Хуульчдын холбооноос АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй”, “АНУ дахь баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт сургалт-хэлэлцүүлгүүдийг 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. 12.Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэн, БНСУ-ын Хувийн эрх зүй судлалын нийгэмлэг, Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран “Монгол-Солонгосын гэр бүлийн эрх зүй, гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт хамтарсан хэлэлцүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. 13.2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Япон Улсын Айчи мужийн Хуульчдын холбооны төлөөлөгч нарыг хүлээн авч уулзсан.
Шагнал урамшуулал				
1.28	Хуульчдыг	төрийн	шагналд	Тухай бүр
				Салбартаа үр бүтээлтэй
				Эзэмшсэн мэрэгжлээрээ хууль зүйн салбарт үр

	тодорхойлох, нэр дэвшүүлэх		ажиллаж Төрийн одон медалийн шагналын болзлыг хангасан хуульчдыг шагнуулахаар уламжилсан байна.	бүтээлтэй ажиллаж байгаа 15 хуульчийг төрийн дээд шагналд тодорхойлж, шагналыг гардуулан өгсөн.
1.29	Хуульчдыг хууль зүйн салбарын шагналд тодорхойлох, нэр дэвшүүлэх	Жилдээ	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан журамд нийцсэн байна.	Хууль зүйн албаны тэргүүний ажилтан 25, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг” 10 хуульчийг шагналд нэр дэвшүүлсэн, шагналыг гардуулан өгсөн.
1.30	Хуульчдын холбооны Шагналын журамд заасан болзол шаардлагыг хангасан хуульчдын материалыг хүлээн авч, Хүндэт тэмдгээр шагнах	Тухай бүр	Болзол шаардлага ирүүлсэн материалуудыг судалж, холбогдох байгууллагад уламжилсан байна.	Хүндэт тэмдгээр 69 хуульчийг шагнаж Цагаан сар, Монгол цэргийн өдөр, Хуульчдын өдөр, Үндэсний их баяр наадмыг өдрүүдэд шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.
1.31	Холбооны шагналын тэмдэг, үнэмлэх, хавтас захиалах, нөөц бүрдүүлэх тэмдэг, үнэмлэх, хавтсыг холбогдох байгууллагад захиалах	1-р улиралд	Шагналын нөөц бүрдсэн байна.	Зоос гоёл ХХК-д 100 ширхэгийг захиалж авсан.
1.32	Тэмдэглэлт өдрүүдээр хуульчдад шагнал гардуулах арга хэмжээг тухай бүр зохион байгуулах	Тухай бүр	Хуульчдыг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан байх	Сар шинийн баяр, Монгол цэргийн өдөр, Хуульчдын өдөр, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан 6 удаагийн шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулж хууль зүйн салбартаа үр бүтээлтэй ажиллаж байгаа хуульчдын холбооны гишүүн хуульчид, Тамгын газрын ажилтнуудыг шагнаж урамшуулсан.
Сонгууль явуулах				
1.33	Чиг үүргийн болон сайн дурын хороодын дарга, тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүд, салбарын зохицуулагчийг сонгох сонгуулийг зохион байгуулах	Жилдээ	Шаардлагатай тохиолдолд сонгуулийг зохион байгуулсан байх	1.2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн 4 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан дээрх орон тоон дээр сонгууль зарлаж С.Оюунгэрэл, Б.Анхбаяр, А.Түвшинтөгс, Б.Золзаяа нар сонгогдсоныг батламжилсан. 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн 3 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан 3 гишүүний орон тоон дээр сонгууль зарлаж С.Халиунаа, Ч.Мөнхболор хуульчид сонгогдсон. Мөн Удирдах зөвлөлийн нэг

				гишүүний орон дээр 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зарласан боловч хангалттай хэмжээний санал аваагүй тул дахин зарлахаар хойшлуулсан. 2.Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны Удирдах зөвлөлийн идэвхгүй, хуралд оролцдоггүй гишүүдийг чөлөөлөх асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцсэн бөгөөд үүний дагуу ажлын ачааллаас болоод хурал, үйл ажиллагаанд оролцох боломжгүй байгаагаа илэрхийлж 2 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөнтэй холбогдуулан нөхөх сонгуулийг зарлаж 5 хуульч нэрээ дэвшүүлснээс 3.Тунгалагмаа, Г.Энхтуяа нар олонхын санал авсныг Хорооны удирдах зөвлөлийн хурлаар батламжлав. 3.Өвөрхангай аймгийн салбарын зохицуулагчийн гэрээний хугацаа дуусгавар болж хүсэлтээ ирүүлсэнтэй холбогдуулан тус аймгийн хуульчдын дунд салбарын зохицуулагчийг сонгох сонгуулийг 5 дугаар сард зохион байгуулж өмгөөлөгч М.Дамбийням сонгогдон ажиллаж байна. 4. Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр сонгууль зарласан. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа: 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагаас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 22:00 цаг хүртэл; Санал өгөх үйл ажиллагаа: 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09:00 цагаас 2025 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 22:00 цаг хүртэл тус тус явагдсан.
Хуульчийн нэгдсэн бүртгэл				
1.34	Хуульчийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх, хуульчдад үйлчилгээ үзүүлэх	Жилдээ	Баримтыг бүрдлийг хангуулсан байна.	1.Хуульчдад утсаар болон биечлэн лавлагааг байнга өгч байна. /үүнд: бүртгэлтэй холбоотой албан бичиг, өргөдөл, хүсэлт, лавлагаа мэдээлэл, хуульчдын сайт

				руу нэвтрэх эрх, татвар,сургалт, өмгөөлөгчийн болон өмгөөллийн нөхөрлөлөлийн утасны дугаар болон бусад мэдээлэл/ 2.Тайлангийн хугацаанд 516 албан бичиг болон өргөдөл, хүсэлтийг хүлээн авч материалын бүрдлийг хангуулж, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтнээр дүгнэлт гаргуулан Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргад танилцуулан хүсэлтийг дүрэм журамд заасныг баримтлан шийдвэр гаргуулж, хариуг хуульчид мэдэгдэж ажилласан. 3.Тайлангийн хугацаанд, Ерөнхийлөгчийн тушаал 256, Тамгын газрын даргын 21 тушаалыг тус тус гаргаж, хуульчид мэдэгдэх, холбогдох бүртгэл, цахимаар болон цаасан хэлбэрээр хадгалах зэрэг ажлыг хийсэн.
ХОЁР.ТАМГЫН ГАЗРЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН ЯВУУЛАХ				
Тушаал шийдвэрийн биелэлтэд хяналт тавих				
2.1	Холбооны Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах	Жилдээ	Журмын хэрэгжилтэд хяналт тавьсан байх	Дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
2.2	Холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын даргын тушаал шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, мэдээ, тайлан гаргах	Улирал тутам	Удирдлагын мэдээллээр хангасан байна.	Тайлант хугацаанд Ерөнхийлөгчийн тушаал 268, тамгын газрын даргын тушаал 60 боловсруулан баталж, хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажилласан.
2.3	Тамгын газрын Удирдлагын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	Тухай бүр	Тамгын газрын төлөвлөгөөнд тусгагдсан болон удирдлагын үүрэг даалгаварын биелэлт хэрэгжүүлсэн байна.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар түүний биелэлтийг хэрэгжүүлж ажилласан.
Төлөвлөгөө, тайлан				
2.4	Хуульчдын холбооны жилийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулах	Тухай бүр	МХХ-ны тухайн жилийн төлөвлөгөөг батлуулсан	1.Хуульчдын холбооны 2025 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төсөлд чиг үүргийн болон

	/хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэн/		байна.	сайн дурын хороодоос саналаа тусгуулахаар ирүүлснийг нэгтгэн Зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлуулсан. 2.Хуульчдын холбооны 2026 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төсөлд чиг үүргийн болон сайн дурын хороодоос саналаа тусгуулахаар ирүүлснийг нэгтгэн Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлуулсан.
2.5	Хуульчдын холбооны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хороодын тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх, хэлэлцүүлэх	Хагас бүтэн жил	Төлөвлөгөөний биелэлт, тайлан, мэдээг хууль, дүрэмд заасан хугацаанд нэгтгэн, тайлагнасан байна.	Тайлант хугацаанд Хуульчдын холбооны 2025, 2026 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулахаар чиг үүргийн болон сайн дурын хороод, орон нутгийн салбарын зохицуулагчид хүргүүлсэн.
2.6	Тамгын газрын жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах	01 сар	Тамгын газрын төлөвлөгөөг батлуулсан байна.	Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Тамгын газрын төлөвлөгөөг батласан.
2.7	Тамгын газрын жилийн төлөвлөгөөний биелэлтэд тухай бүр хяналт тавьж, төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэх, тайлагнах	Хагас, бүтэн жил	Тамгын газрын төлөвлөгөөний хэрэгжилт, мэдээ, тайлан хууль, дүрэмд заасан хугацаанд нэгтгэн, тайлагнасан байна.	Хяналтын зөвлөлд Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хороодын тайлан, хороодын хурлын мэдээ, тоон мэдээ, гэрээний бүртгэлийг тус тус боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 2/632 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
2.8	Тамгын газрын санхүүгийн тайланг гаргаж холбогдох газар, /Хяналтын зөвлөл/-д хүргүүлэх	Хагас, бүтэн жил	Санхүүгийн тайлан, мэдээ Хуульд, дүрэм, журамд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлж, тайлагнасан байна.	Тамгын газрын 2025 оны эхний болон сүүлийн хагас жилийн тайланг боловсруулж, Хяналтын зөвлөлд албан бичгээр хүргүүлсэн. Эхний хагас жилийн Тамгын газрын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн хяналт шалгалт хийж Зөвлөлийн хуралд танилцуулсан.
2.9	Холбооны Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргын олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, уулзалт, өдөр тутмын ажилд туслах, хэвийн ажиллах	Жилдээ	Холбооны удирдлагуудын өдөр тутмын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	Холбооны Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргын олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа, уулзалт, өдөр тутмын ажилд туслах, хэвийн ажиллах нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн үйл ажиллагааг

	нөхцөлөөр хангах			календарьд төлөвлөн бүртгэж хуульчид, иргэдийг хүлээн авч хүсэлтийг сонсож, шийдвэрлэн ажиллаж байна. Ерөнхийлөгч нийт 173 уулзалт, 29 хэлэлцүүлэг, арга хэмжээ, 8 санамж бичиг, 3 олон улсын эрдэм шинжилгээний хурал, 3 шагнал гардуулах арга хэмжээнд оролцсон. Тамгын газрын дарга 302 уулзалт, 43 хэлэлцүүлэг, арга хэмжээ, 9 удаа ажлын хэсгийн хурал, 7 санамж бичиг, 4 шагнал гардуулах арга хэмжээнд оролцсон.
2.10	Холбооны дүрмийн 6.6 дугаар зүйлийн 3.2-д заасан гэрээ, хэлцлийг батлагдсан маягтын дагуу бүртгэж, дугаар өгөх, хадгалах, архивлах	Тухай бүр	Шаардлагатай нөхцөлд мэдээллийг ашиглахад бэлэн байлгана.	Тайлант хугацаанд иргэн аж ахуйн нэгжтэй 114 гэрээ байгуулсныг бүртгэлжүүлсэн.
2.11	Сар, улирлын мэдээ, тайланг хугацаанд нь гаргах, бүртгэл хөтлөх, хяналт тавих, Удирдлагуудад танилцуулах	Тухай бүр	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтнууд тайлан, мэдээг хугацаанд нь гаргах, тайлагнах	Хуульчдын холбооны 2025 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний нэгдүгээр улирлын биелэлтийг нэгтгэж боловсруулж Зөвлөлийн хуралд танилцуулсан. Тамгын газрын ажилтнууд 2025 оны 1, 2 дугаар улирлын ажлын биелэлт, мэдээ тайланг гаргасан.
2.12	Тамгын газрын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, хангуулах	Тогтмол	Хэрэгжилтийн дүнг сар тутам гаргаж танилцуулсан байна.	Тамгын газрын ажилтнуудын ажилласан жил, үр дүнг тооцож, урамшуулал олгох журмын хэрэгжилтийг ханган 2025 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын ажилтнуудын үр дүнгийн урамшууллыг олгосон.
2.13	Хөдөлмөрийн гэрээний болон албан тушаалын тодорхоллолтод заасан чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих	01 сар	Ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүргийг тодорхой болгох, ажлын бүтээмж сайжирсан байна.	Хяналт тавьж ажилласан.

2.14	Ажлын цаг ашиглалтад хяналт тавих, ажилласан цагийн бүртгэлийг баталгаажуулах, цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгох	Тухай бүр	Ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, цалинг тогтоосон хугацаанд олгосон байна.	Тайлант хугацаанд 24 удаа цагийн бүртгэлийг гаргаж, санхүүд хүргүүлж дотоод журамд заасан хугацаанд цалин хөлсийг олгосон.
2.15	Дотоод томилолтоор орон нутагт ажиллах ажилтнуудыг бүртгэж, томилолтын хуудас олгох, бүртгэл хөтлөх, ажилтнуудаас саналыг авч ээлжийн амралтын хуваарь гаргаж батлуулж ажилтнуудад танилцуулах	Тухай бүр	Байгууллагын дотоод ажил хэвийн явагдсан байна.	Тайлант хугацаанд орон нутагт томилолтоор ажиллаагүй, харин ажилтнуудын 2025 оны ээлжийн амралтын хуваарийг Тамгын газрын даргын тушаалаар баталж, ажилтнуудыг хуваарийн дагуу амруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулсан.
2.16	Ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж тогтоосон хугацаанд дүгнэх	Хагас, бүтэн жил	Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Тайлант хугацаанд 22 ажилтны хөдөлмөрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн 1, 2, 3, 4 дугаар ажлын биелэлтийг авч, дүгнэн ажилтнуудад урамшууллыг олгосон. Мөн Хуульчдын мэргэжлийн шалгалт, Хуульчдын Их хурал, форум зэрэг томоохон үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулсан илүү цагийн хөлсийг хуулийн дагуу ажилтнуудад олгосон.
Тамгын газрын ажилтнуудын хүний нөөц, сургалт, хөгжил, ажилтнуудын нийгмийн асуудлыг зохион байгуулах				
2.17	Ажилтны мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;	Тухай бүр	Сургалт зохион байгуулж ажилтнуудыг чадавхижуулсан байна.	- Тамгын газрын ажилтнуудад долоо хоногийн мягмар, пүрэв гарагуудад англи хэлний үнэ төлбөргүй сургалтыг хуульч Ц.Одонжав зохион байгуулж байна. Мөн ажлын цагаар англи хэлний мэдлэгээ дээшлүүлэхээр сургалтад хамрагдах болсон 1 ажилтны ажлын цагт зохицуулалт хийж сурах боломжоор хангасан. - Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан Комплаенсын ажилтныг мэргэшүүлэх ахисан шатны сертификаттай сургалтад Тамгын газрыг ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн, мэргэжилтэн Г.Хосцэцэг нар хамрагдсан. - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас аж ахуйн нэгж, байгууллагуудад

				Хөдөлмөрийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх зорилгоор мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтыг 2025 оны зургадугаар сарын 12-14 өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн В.Болормаа, Г.Халиун, Ч.Өнөржаргал, Э.Золжаргал, Тамгын газрын ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн нар хамрагдаж, “Мэргэшсэн зөвлөх”-ийн гэрчилгээ авсан. - Маркетинг академитай хамтран “Хиймэл оюун” сургалтыг Тамгын газрын ажилтнуудад зохион байгуулсан.
2.18	Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, спортын уралдаан, тэмцээн, өдөрлөгийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан батлуулж зохион байгуулах;	Жилдээ	Төлөвлөгөө, төсөв батлуулж уралдаан тэмцээн явагдсан байна.	1.Монос групптэй хамтран Хуульчдын өдрөөр эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж холбооны гишүүн хуульч, Тамгын газрын ажилтнууд зэрэг 87 хүн хамрагдлаа. Өдөрлөгөөр дараах үйлчилгээг үзүүлэв. Үүнд: - Эрдсийн шинжилгээ - Сахар үзэх - Хэвлийн эхо - Арьс оношилгоо - Шүд - Хөнгөлөлттэй үнээр витаминь худалдаа. 2.Гануу хатан эмнэлэгтэй хамтран 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Зөвлөлийн гишүүд, Тамгын газрын ажилтнуудыг хамруулж эрдсийн шинжилгээг үнэ төлбөргүй авч, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгсөн.
2.19	Ажилтнуудад нийгэм, ахуйн тусламж, дэмжлэг үзүүлэх.	Жилээр	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж дэмжлэг үзүүлсэн байна.	- Шинээр хүүхэдтэй болсон 2, ар гэрийн гачигдал гарсан 1 ажилтан, 3 хуульчид нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон. - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, шинэ жилийн баярын өдрөөр ажилтнуудын хүүхдүүдэд тус бүр 50,000 төгрөгийн үнэ бүхий бэлэг өгсөн. - Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан 70

				дээш настай 15 ахмадад гарын бэлэг өгч, хүндэтгэл үзүүлсэн.
2.20	“Хуульчдын холбооны шилжин явах цом-2025” зургаан төрөлт спорт тэмцээнийг зохион байгуулах	05 дугаар сар	Спорт тэмцээнийг зохион байгуулсан байна.	Хэрэгжээгүй
Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг заавар, журам, стандартын дагуу хэвийн явуулах				
2.21	Хуульчдын холбоо, Тамгын газар, хороодод ирсэн бичиг, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж, хугацаанд нь хариу хүргүүлэхэд хяналт тавих	Тухай бүр	Байгууллага, иргэдийн хүсэлтийг шийдвэрлэж, хариу хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд 1994 албан бичиг хүлээн авснаас хариутай бичиг 1935, хариугүй 57 хүлээн авсан, үүнээс хуулийн хугацаанд хариу өгсөн 1967 албан бичиг, шийдвэрлэх шатанд хяналтад 17 албан бичиг байна. Мөн 984 албан бичгийг боловсруулан иргэн, хуулийн этгээдэд явуулсан.
2.22	Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж 14 хоног тутам мэдээ гаргах, удирдлагад танилцуулах	14 хоног тутам	Хяналт тавьж, дүн мэдээг тухай бүр танилцуулсан байна.	Хариутай бичгийн мэдээ тайланг 14 хоног тутам гаргаж удирдлагад танилцуулж, ажилтнуудад албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгөх талаар тухай бүр мэдээлсэн.
2.23	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар бүртгэл хөтөлж, хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхэд хяналт тавьж, явцын тайлан гаргана.	Жилдээ	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.	Тайлант хугацаанд 1994 өргөдөл хүлээн авснаас 1857 өргөдөлд хариу өгсөн, 81 өргөдлийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, хяналтад буюу шийдвэрлэх шатанд 17 өргөдөл байна.
2.24	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдол санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар бүртгэл хөтөлж, шийдвэрлэлтийн талаарх явцын тайлан гаргана.	14 хоног тутам	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.	Тайлант хугацаанд 1500 хүсэлт цахимаар хүлээн авч хариу өгсөн.
2.25	Холбооны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан батлуулах, ажилтнуудад танилцуулах	1-р улирал	ХХНЖ-ын дагуу ажилтнууд 2024 онд үүсч хөтлөгдөх баримтыг зөв зохион бүрдүүлсэн байна.	Хэрэгжээгүй.
2.26	2024 үүсч хөтлөгдсөн баримт бичгийг зааврын дагуу архивт нэгж бүдүүлж, бүртгэлээр хүлээн авах, бүртгэлжүүлэх	1-р улирал	Баримтуудыг хүлээн авч, Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу бүртгэл хөтлөх	Байгууллагын архивын нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан зарим мэргэжилтнүүдээс 2024 оны 50 гурай хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авсан.

2.27	Байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг явуулах	Жилдээ	Байгууллагын архивын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Хэрэгжээгүй
2.28	Тамгын газрын ажилтнууд өөрийн эрхэлсэн ажилтай холбоотой тухайн жилд боловсруулсан, үүсэж хөтлөгдсөн бүхий л баримт бичгийг архив зүйн үүднээс хугацаанд нь үдэж хавтаслан байгууллагын архивт шилжүүлэх	1-р улирал	Архивын үйл ажиллагааг хэвийн явуулах	50 гаруй баримтыг байгууллагын архивт хүлээн авсан.

ТАМГЫН ГАЗАР